



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 24 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төв Банк /Монголбанк/-ны тухай хуулийн 30 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмсүгэй.

“5.Монголбанк өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. ”

2 дугаар зүйл. Төв Банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурал” гэсний дараа “нэр дэвшигчийн сонголт хийж” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурал” гэсний дараа “нэр дэвшигчийн сонголт хийж” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Төв Банк /Монголбанк/-ны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “улирал тутам” гэснийг “шаардлагатай тохиолдолд” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР